

БОГД ЗОНХАВЫГ МОНГОЛ ХҮН ГЭХ ЗАРИМ МЭДЭЭ БАРИМТ

Д. Бат¹

Нэг. Зонхава гэгээний товч намтар

Зонхава гэгээн (tsong kha pa 1357-1419) бол Юань улсын Жи Жэнгийн арван долдугаар он, улаагчин тахиа жил (1357 он) мэндэлж, Мин улсын Юн-Ло-гийн хорин долдугаар он, 1419 онд жаран хоёр настай таалал төгсчээ. Тэр Хөхнуурын Зонха гэдэг газар төрсөн тул уг газрын нэрээр нь Зонхава хэмээн алдаршсан бөгөөд Зонха хэмээх газрын хүн гэсэн утгатай аж. Харин түүний жинхэнэ нэрийг Лувсандагва (blo bzang grags pa) гэдэг. Эцгийн нэрийг Дарахач (da ra kha chi - Даргач гэсэн монгол үг), эхийг нь Шинсаа-Ачой (shin bza a chos) гэдэг. Лувсандагва бээр долоон наснаасаа Хөхнуурын Жачүн хийдэд шавилан суужээ. (Учир нь тухай үед Гүмбүм хийд буй болоогүй байв) Түүний багш нь Чойжидондүбринчэн (chos rji don grub rin chen) хэмээх хүн байсан бөгөөд тэр бээр Гарма гажүдба (krma bka'a brgyud)-гийн чиглэлийн лам байв. Чойжидондүбринчэн багштан бол угтаа төвдийн Нартан хийд (snar thang dgon pa)-д их ном сурч ирсэн нэгэн байжээ. Лувсандагва бээр арван долоон насандаа Зууд хүрээд, Гарма гажүдба зэрэг бурханы шашны олон чиглэл бүлэгтний зуун багшийг шүтэж, эрдэм ном нь цаглашгүй их болж тэрхүү олон багш нарынхаа эрдмийг, айргийг бүлж тосыг ялган авдаг адилаар аль шим төгс сайныг нь сурч эзэмшсэн ажээ. Гэвч тэдгээр олон шашны бүлэг чиглэлтний дотроос хамгийн гол шүтээн болгосон нь Зуу-Адиша (a ti sha) гэгээний сургаал номлолын дэг сургууль байсан бөгөөд мөн энэ суурь дээрээ шарын шашны сургаал номлолын чиглэлийг буй болгожээ.

Зонхава гэгээнтэн бээр Шарын шашныг тогтоохдоо дөрвөн их үйлийг бүтээсэн бөгөөд түүнийг нь дөрвөн их зохионгуй (tsong kha ba'i mdzad chin bzhi) гэдэг.

Нэгд: Зин ши (rdzing phyi) хэмээх газарт байсан Майдар (byams pa) бурханыг сэлбэн засаж шүтээн болгон залжээ. Энэхүү Майдар бурхан байсан орон хийд нь Зонхава-г морилон очихоос аль өмнө, олон жил хамаарах эзэн, шүтэх ламгүй болж, улмаар уг бурхны шуумал доторх алт эрдэнэсийг хүмүүс ухаж, малтан авсан тул, сүмд нь шувуу үүрлэж, өлсгөлөн ядуучууд орогнож суудаг газар болсон байжээ. Зонхава гэгээнтэн бээр тэр сүмд амьдарч байсан ядуу хүмүүст өглөг өгч, тэднийг өөр газар орон гэртэй болгон явуулаад, Майдар бурхан тэргүүтэн шүтээн, сүм хийдийг өглөгийн эздийн хөрөнгөөр засаж, хурал номын газар болгож, тэр сүмийг хуучны хэвд нь оруулжээ. Энэ бол түүний нэгдүгээр гавъяа юм.

Хоёрт: Нял (gnyal) хэмээх газарт ном номлодог нэгэн хүрээ байжээ. Түүнийг Нялжилүнрачэнмо (gnyal gyi lung gwa chen mo) гэдэг. Зонхава гэгээнтэн энэ хүрээнд

¹ Баруун хойтын үндэсний их сургууль

ном тавьж, хурал номыг удирдсан өдрөөс эхлэн сонсох, шүтэх хүн нэн арвин болж, сүсэгтэн олон болон шавь хуврагууд Зонхава гэгээнтнийг үнэнхүү шүтэн биширч, дөрвөн аймгийн шашны бүх ёсыг мэддэг мэргэн хүн байна хэмээн гайхацгааж, Зонхава гэгээнтний алдар эндээс анх ихэд мандсан ажээ. Зонхава гэгээнтэн нь тухайн үеийн бурханы шашны олон бүлэг чиглэлийн хамгийн шилдэг сайныг нь сонгон авч, шарын шашныг тогтоосон тул тэр олон бүлэгтний дээд лам нар нь Зонхава гэгээнтнийг даган биширсэн тул бусад олон бүгдээр аяндаа дагалджээ. Энэ бол түүний хоёрдугаар гавъяа юм.

Гуравт: Лхас Монламчэнмо (lha sa'i smon lam chen mo) буюу Мөнхзуугийн ерөөлийн их хурлыг Галдан хийдэд анх үүсгэн буй болгожээ. Тэр нь цагаан сарын шинэдээс эхлэн зургаан түмэн лам, хорин нэгэн өдрийн хурал хурж, ерөөл тавьдаг их зан үйл болно. Энэ бол түүний гуравдугаар гавъяа юм.

Дөрөвт: Галдан хийдийг байгуулан, Галдандүвчодчэнмо (dgal ldan sgrub mchod chen mo) хэмээх нууц тарнийн номыг хурж, их үйлийг бүтээсэн ажээ. Энэ бол түүний дөрөвдүгээр гавъяа юм. Энэ дөрвөн гавъяа буюу зохионгуй нь Зонхава гэгээнтний шарын шашныг тогтоох үндэс суурь болжээ. Тэр үед Зонхава гэгээнтэн 52 настай байжээ. Даруй 1409 оны үе байв.(3)

Хоёр.Зонхава богд монгол хүн болох нь

Зонхава богд нь ямар хүн байсан тухай маргасан зүйл байхгүй юм. Учир нь төвдийн сурвалж бичигт түүнийг монгол хүн гэж бичиж байжээ. Мөн Гансу мужийн Лавран хийдийн Жамъяншадав гэгээнтний ботид ч монгол хэмээн бичиж буй. Түүнээс гадна бас цөөнгүй баримт жишээ буй. Жишээлбэл:

1. Ойрдын Гүүш хаан Төвдийг эзэлж, шашин төрийг зэргээр атгаж байсан талаар тухайн үеийн төвдийн түүх бичигт Гүүш хааныг эсэргүүцэн бичихдээ “Гүүш хаан бол Зонхава гэгээнтний шашныг дэмжиж байгаа нь Төвдийн орон, төвд хүмүүст сайн үйл үйлдэх гэсэндээ бус, харин Зонхава гэгээнтэн нь монгол хүн байсан тул монголдоо л ашиг тустай үйл хийсэн төдий юм хэмээн Гүүш хааны түүхэн үйл хэрэг, гавъяа зүтгэлийг үгүйсгэсэн байдаг. Энэ мэтийг бичсэн номыг [зураг] Агваанчойдор гуай Төвийн Үндэсний Их Сургуулийн профессор Дунгарлуvsанпрэнлэй (dung dkar blo bzav 'phrin las) гуайн цуглуулга номоос хуулбарлаж авсан ажээ.

2. Хятадын иргэн улсын аравдугаар оны 6 сард Шанхай хотод хэвлэгдсэн “Дундад улсын хүний нэрсийн том толь” (中国人名大辞典) –ийн 590 дүгээр хуудсанд Зонхава гэгээнтнийг монгол хүн болно гэж тэмдэглэсэн байна. Уг эхийг хавсралт зураг 1-ээс үз.

3. Зонхава гэгээний ээж Шинсаа-Ачой бол төвд хүн байж магадгүй харин эцэг нь монгол хүн бөгөөд Юань улсын үед даргач ноён байжээ. Нэр нь Лүнбүмгэ (klu 'bum dge) гэдэг. Энэ Лүнбүмгэ гэдэг нэр нь хаанаас ирсэн буй гэвэл 13-р зууны үед Монголын Годан хаан Төвдийн Сажа Бандид Гунгаажалцаныг Лянжоу (Эдүгээгийн Хятадын Ганьсү мужийн Ү Вэй хот)-д залж ирсний дараа, эдүгээгийн Хөхнуурын Синингийн орчим газрыг зургаан хошуу аймаг (tsho ba drug)-т хуваан өгч, тэднээр захируулах болов. Тэр Зургаан аймаг нь Лүнбүм аймаг (klu'abum tsho ba), Сина аймаг (zi na tsho ba), Минаг аймаг (mi nyag tsho ba), Шинжон аймаг (zhing skyong tsho ba); Чи жа аймаг (chi kya tsho ba), Шагба аймаг (zhags pa tsho ba) гэж тус тус нэрлэдэг байжээ. Тэдгээрээс Лүнбүм аймаг, Чи жа аймаг, Сина аймаг гурвыг монгол хэмээдэг, бусад гурав нь төвд ажээ. Лүнбүм гэдэг үг бол арван түмэн лусыг заасан олон (Энэ нь маш олон гэсэн бэлгэдлийн тоо) булаг гэсэн үг юм. Лүнбүм аймгийн хүмүүс бол угтаа

Хөхнуурын монголчууд билээ. Зонхава богдын эцэг нь энэ Лүнбүм аймгийг даргалж байсан учраас Лүнбүмгэ хэмээсэн нэртэй байжээ. (4)

Гурав. Зонхава богдын намтарт түүнийг монгол хүн гэж бичээгүйн шалтгаан

Зонхава богдын үүсгэсэн шарын шашны чиглэл нь ямар нэгэн улс үндэстэнд харьяалагдах зүйл бус бөгөөд бурхан багшийн шашны үндсэн зорилго нь их болсон зургаан зүйл амьтныг үл ялган, сайн сайханд хүргэх, ариусган гэгээрүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, шарын шашин бол Төвдийн ч биш, Монголын ч биш, харин хүн төрөлхтөнд зориулагдсан сургаал номлол билээ. Ийм учраас шарын шашинд Монгол, Төвд гэж үндэстэн ялгахгүй, цөм нэгэн үзүүрт сэтгэлээр чухаг дээд гурван эрдэнэд аврал одуулж, хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэхийг л зорьдог ёстой билээ. Тиймийн тул, ямар нэгэн хутагт гэгээнтэн, тухайлбал, Богд лам Зонхава нь өөрийгөө ямар ястан, ямар угсаатан болохыг огт чухалчлахгүй, харин үнэн сэтгэлээр бурханы үйлсийг гүйцэтгэж чадаж байгаа эсэхээр л өөрийн биеэн шалгадаг учиртай болно. Мөн иймэрхүү нэгэн жишээг дурдвал, Ойрдын Гүүш хаан Төвдийг эзэлсний дараа, Төвд газарт Тавдугаар далай ламтай хамтарч “Галданповранчоглайнамжил” (“dga’ a ldan pho brang phyogs las nam rgyal”) хэмээх Төвдийн ч биш, Монголын ч биш нийтийг хамарсан “Зүг болгоноос илт олсон шашны их орд” хэмээх утгатай төрийн захиргааг буй болгожээ. Ийм учраас тухайн үед Энэтхэгийн хаан, Гүүш хааныг биширч сайшаан, маш нандин шүтээн болох есөн өнгийн гэрэл гардаг бугын арьс болон Шан шан дэү (shang shang de’u) -гийн бүтээсэн хэмээдэг маш яруу дуу гардаг нэгэн зүйл цан зэргийг бэлэглэсэн түүхтэй ажээ. (5)

Нөгөө талаас Юань улс мөхсөний дараа, Мин улсын цэрэг дайран орж ирэхэд, монгол угсаатай ихэнх хүмүүс нь уг гарлаа нууж, зарим нь өөр үндэстэн мэт болсон жишээ ч буй. Жишээлбэл: Гансү мужид байгаа Дунсянь үндэстэн бол тухайн үед Сономба гэдэг хүн толгойлж байсан тул, Мин улсын цэрэг хүрч ирэхэд “ Бид Монгол биш, Сономба байна” гэсэнд, Мин улсын цэрэг тэднийг газрын байрлалаар нь Дунсянь гэж нэрийджээ. Дунсянь гэдгийг Хятадаар (东乡) гэж бичдэг бөгөөд Зүүн нутгийнхан гэсэн үг болно. Үүнтэй адилаар Зонха газрын зургаан аймаг хүмүүс нэр усаа нууж байсан буюу нэг ихээр угсаа гарал, овог төрлөө тодорхой хэлдэггүй байсан ч байж болох юм.

Ерөнхийлөөд хэлбэл, Зонхава богд нь язгуур гарлын хувьд, монгол хүний уг удамтай байсан боловч, үүдэж бүтээсэн нь хүн төрөлхтний тусын тулд их үйлийг бүтээж явсан болохоор, дэлхийн соёлын түүхэнд гайхамшигтай үр бүтээлийг гаргаж, бурхан шашны их үйлсийг онц хөгжүүлсэн хүн гэж алдаршсан юм.

Тайлбар зүүлт:

- (1) Зуу-Адишагийн гэгээнтэн бол 1042 онд Энэтхэгээс Төвдөд залагдан ирж, 1054 онд таалал төгсчээ. Төвдөд нийт 13 жил суужээ. Түүний сууж байсан хийдийг Нитан (sni thang) гэдэг (Эдүгээ буй). Нитан хийдэд Төвдийн Лавзан хаан (монгол), хорин нэгэн дарь эх хийж тавьсан буй. Зуу-Адишагийн гэгээнтэн энэ хийдэд таалал төгссөн болохоор, шарил нь мөн энэ хийдэд байв. 1979 онд Энэтхэгээс хүмүүс ирж, тэр шарилыг нь авч явжээ.
- (2) (3)(4)(5) Баруун Хойтын Үндэсний их Сургуулийн профессор Агваанчойдор (1918-) гуайн ярьсан “ Монгол Төвд бурхан шашны аман түүх” –ийн материал.

SUMMARY

There is no argument about who Bogd Zonhawa was, because he was said to be a Mongolian in Tibetan sources. Also he was mentioned as being Mongolian in the books written by Jamiyanshadam of Lavran monastery, Gansu region. Furthermore, the author found several additional sources proving that Bogd Zonhawa was a Mongolian.

зүрэг 1

宗喀巴 國喇嘛黃教之祖。一名
羅卜藏札克巴。明永樂十五年。生於
西寧。爲蒙古族之人。幼名阿劫。八
歲出家。後赴西藏。開明黃教。有二
大弟子。曰達賴喇嘛。曰班禪額爾德
尼。皆傳化身轉世。輪迴不已。